

Хайртай

гэдгийг минь

тэдэнд

хэлээрэй

ЖОЙС МАЙЕР

Хайртай гэдгийг минь
ТЭДЭНД ХЭЛЭЭРЭЙ



БУРХАН ТАНЫГ ХАЙРЛАДАГ
ТУХАЙ ЭНГИЙН ҮНЭН

ЖОЙС МАЙЕР

Улаанбаатар
2018

Номонд ашиглагдсан бүх Библийн эшлэлүүдийг Ариун Бичээс Библийн Нийгэмлэгийн 2004 оны «Ариун Библи»-ээс болон нэмэлт хашилтай эшлэлүүдийг (The Amplified Old Testament, copyright © 1965, 1987 by Zondervan Corporation, Grand Rapids, Michigan. The Amplified New Testament, copyright © 1958, 1987 by The Lockman Foundation) дэлгэрэнгүй тайлбар Библээс орчуулан бичсэн болно.

Англи хэлээр эх нь **TELL THEM I LOVE THEM**

Зохиогчийн эрх © 2015 Зохиогч: Жойс Майер
© Жойс Майерийн үйлчлэл

ХАЙРТАЙ ГЭДГИЙГ МИНЬ ТЭДЭНД ХЭЛЭЭРЭЙ

Бурхан танд хайртайн тухай энгийн үнэн

Жойс Майер

Mongolian

ISBN 978-99962-0-857-7

Худалдахыг хориглоно!

Зөвхөн үнэгүй тараахад зориулагдсан.

Бүх эрх хамгаалагдсан. АНУ-ын Зохиогчийн эрхийн 1976 оны Актын дагуу, энэхүү номын ямар ч хэсгийг хэвлэлийн газрын зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, мэдээллийн системд оруулах, электрон хуулбараар тараах зэрэг нь зохиогчийн эрхийг зөрчиж, зохиогчийн оюуны өмчийг хулгайлж байгаа хууль бус хэрэгт тооцогдоно.

Зохиогчийн эрхийг хүндэлж буй танд баярлалаа.

Гарчиг

Өмнөх үг	5
Бурхан танд хайртай!	8
Би хангалттай сайн байж чаддаг билүү?	16
Хайр бол харилцаа мөн	26
Хайр, найдвар, итгэл	35
Айдсаас чөлөөлөгдөх нь	43
Хайр бусдад хүрдэг	49
Бурханы хайр таныг өөрчилнө	55
Итгэлийн залбирал	59
Зохиогчийн тухай	61

ӨМНӨХ ҮГ

Хүмүүст юу юунаас илүүтэй тэдний төлөөх Бурханы хайрын илчлэлт хэрэгтэй гэж би итгэдэг. Энэ нь бидэнд Түүнтэй ойр дотно, хувьчилсан харилцаатай байх болон жинхэнэ ялалт дүүрэн итгэгч хүний амьдралын үндэс суурийг тавьж өгдөг тэрхүү ойлголт юм. Бурханы хайрын талаар бидэнд онолын мэдлэг хэрэггүй, харин бидэнд түүний тухай илчлэлт хэрэгтэй. Энэ илчлэлт зөвхөн Ариун Сүнсээр өгөгдөнө. Тэгэхдээ Бурханы хайрыг ойлгон ухаардаг, Түүнийг амьдралдаа мэдэрдэг, залбирал болон Бурханы Үгээр дамжуулан тэрхүү илчлэлтийг эрэлхийлдэг хүмүүст өгөгдөх болно.

Бурхан энэ дэлхийг үнэхээр их хайрласан учраас Өөрийн цорын ганц Хүү Есүсийг

илгээж, үхэлд тушаасан гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хялбар байдаг. Хэрэв та энэ дэлхий дээрх цорын ганц хүн байсан ч Бурхан ганцхан таныг хайрласныхаа төлөө Есүсийг илгээсэн гэдэгт итгэхэд жаахан хэцүү санагддаг.

Олон жил урам хугарч, арга мухардсан Христэд итгэгч явсны эцэст би Бурханы хайрыг ойлгосон юм. Бурхан Ариун Сүнсээрээ дамжуулан надад зориулагдсан Бурханы хайрын тухай илчлэлтийг жинхэнэ утгаар нь мэдрүүлж билээ. Тэр илчлэлт миний амьдралыг бүхэлд нь өөрчилсөн. Түүнээс хойш Бурхантай харилцах миний харилцаа ч өөрчлөгдсөн.

Миний залбирал бол та энэ номыг унших үедээ зөвхөн танд зориулан хувьчилсан, Бурханы хайрын тухай илчлэлтийг ойлгож аваасай гэдэгт байгаа юм. Та энэ номыг яаралгүй уншиж Библи дэх Бурханы хайрын тухай эшлэлүүдийг тунгаан ойлгож, илүү ихээр судалж мэдэхийн тулд нэмэлт материал болгон ашиглаарай гэж би танд зөвлөх байна.

Бурхан танд маш их хайртай. Түүнчлэн түүний хайрыг та өдөр бүр, амьдралынхаа мөч бүр дээр яг миний амьдралыг өөрчилсөн шиг

мэдрээсэй гэж Тэр хүсэж байна. Тиймээс одоо энэхүү номыг та бүхэнд өргөн барихын ялдамд, би бол Бурханаас ангид хэн ч биш, агаад Түүний Үгийн тухай надад буй алив илчлэлт хийгээд ойлголт нь зөвхөн Түүний нигүүлслээр өгөгдсөн гэдгийг хэлэх байна.

Жойс Майер

БУРХАН ТАНД ХАЙРТАЙ!

*«Бурхан ертөнцийг үнэхээр хайр-
ласан тул цорын ганц Хүүгээ өгсөн.
Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөх-
гүй, харин мөнх амьтай болох юм».*

— ЙОХАН 3:16

Бурхан гэр бүлийг хүсдэг, түүнчлэн Тэр бидний Эцэг байхыг хүсдэг. Түүнтэй хувьчилсан харилцаатай байх болон Есүс Христ бидний төлөө амиа өгснөөр бид хангалуун амьдралаар амьдрах ба охид хөвгүүд нь болохын тулд бид бүтээгдсэн юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл тэр биднийг Өөрт нь найдаж, Өөрөөс нь зуурч, Өөрийг нь түшиж, Өөрийг нь хайрлаж, бас биднийг хайрлах боломжийг

Өөрт нь тавьж өгдөг байгаасай гэж хүсдэг. Хүнд хэцүү үедээ Өөрт нь найдаж, Өөртэй нь холбоотой байхыг Бурхан биднээс хүсдэг Тэрээр тантай хувьчилсан харилцаатай байхыг хүсдэг.

Бидний ихэнх нь Иохан 3:16-г хэтэрхий өргөн хүрээнд ойлгодог. «Тийм ээ, Есүс энэ дэлхийн төлөө нас барсан гэж би мэднэ» гэж бид хэлдэг. Гэхдээ бид өөрсдийгөө энэ «дэлхий дээрх» тэр олон хүмүүсийн нэг төдийхнөөр үзэж болохгүй. Учир нь Есүс бидний хүн нэг бүрийн төлөө амиа өгсөн. Тэр таны төлөө үхсэн!

Хэрвээ та энэ дэлхий дээр цорын ганцаараа байсан ч Есүс таны төлөө үхэх л байсан. Тэр таны төлөө тэр бүх зовлон шаналалыг бүгдийг нь туулсан. Тэр таны төлөө тэвчсэн юм шүү! Бурхан танд маш их хайртай. Түүний хайр бол үүрд мөнхийн юм (Иеремиа 31:3 үз).

Нэг өдөр машинаа бариад явж байтал Бурхан миний зүрх сэтгэлд шивнэж хэлэхдээ «Жойс, чи бол Миний нүдний цэцгий» гэж хэлсэн юм. Гэтэл яг тэр үед диавол надад «Ингэж бодох чинь бардамналын нэг илрэл биш үү? Чи өөрийгөө хэн гэж бодоов?» гэж

асуув. Тэр даруй надад «Өө, би ийм юм бодох ёсгүй шүү дээ» гэсэн бодол төрсөн.

Бид өөрсдийгөө онцгой, бэлгийг хүлээн авсан, бусдаас өөр хүмүүс гэдгээ ойлгосон ч гэсэн, ихэнхдээ бид өөрсдийнхөө тухай юу гэж боддог бодлынхоо эсрэг явдаг. Харин Бурхан Эцэг маань олон хувилбарт дуртай бөгөөд Тэр таныг өөрийн гэсэн онцлогтой байхаар бүтээсэн. Харин Тэр юуг хүсэхгүй вэ гэвэл. Та өөрийгөө бусадтай харьцуулах юм уу, эсвэл бусадтай адил байх гэж хичээдэг занг хүсдэггүй. Тэр таныг яг хэрхэн бүтээсэн тэр л байдлаараа байх ба түүгээрээ та онцлог юм.

Ийнхүү бодож байтал Бурхан надад дэлгүүрт дүүрэн алим овоолсон лангууны дэргэд зогсож буй нэгэн эмэгтэйг харуулав. Тэр эмэгтэй лангуу тойрч алимнуудыг харж нэлээд явж байснаа хамгийн сайн нэгийг нь сонгов. Бурхан үүгээр дамжуулан чи бол Миний хамгийн сайн «алим» гэж надад хэлсэн юм. Би бол онцгой нэгэн. Ингэж хэлэх нь зохисгүй юм шиг санагдаж байвч Бурхан энэ үгийг хүн бүрд хувьчлан хэлдэг. Гэхдээ энэ нь чи л ганцхан сайн харин бусад нь муу гэсэн үг биш юм. Харин Тэр бусдаас илүү онцгой гэж хэлж байна. Бурханы үгэнд ч ингэж хэлдэг бөгөөд энэ

үг хүн бүрд зориулагдсан билээ. Иймд та, Бурханы мэлмийн цэцгий билээ.

Өөрийнхөө талаар ингэж бодох нь буруу юм шиг санагдаж байсан учраас тэр үед Бурханы надад хэлсэн үгийг би хүлээж аваагүй. Гэвч хоёр хоногийн дараа Библиэ нээтэл *«Намайг нүдний цэцгий мэт хамгаалаач. Давчнуудынхаа сүүдэрт намайг халхлаач»* гэсэн Дуулал 17:8-р эшлэл гарч ирсэн юм. Тэгэхэд би «Өө, Тэр үнэхээр Бурхан байна шүү дээ. Би Бурханы нүдний цэцгий юм байна» гэж хэлсэн. Түүнээс хойш энэ тухай бодох бүрд би бол маш онцгой гэсэн мэдрэмж төрдөг болсон. Та Бурханы хувьд маш их эрхэм бөгөөд Тэр танд өөрийгөө онцгой, үнэ цэнэтэй, эрхэм бөгөөд хайрлагдсан гэдгээ мэдээсэй гэж хүсдэгийг мэддэг үү?

Хүмүүс бусдаар хайрлуулахсан гэж зүрх сэтгэлдээ хүсэж, мөрөөдөж, тэмүүлж явдаг. Бурхан биднийг ингэж бүтээсэн. Бурхан дэлхийг хайрласан, Тэр Есүсийг хайрласан гэж олон хүн итгэдэг боловч Харин «Бурхан үнэхээр надад хайртай гэж үү» гэж бодмоор хүнд хэцүү цаг тэдэнд ирдэг. Гэсэн ч Бурхан Есүсийг хайрладаг шигээ таныг ч мөн адил их хайрладаг гэж Түүний Үг бидэнд заадаг.

Тэрээр Есүсийг хайрладаг шигээ таныг ч бас тийнхүү агуугаар хайрладаг. Үүнийг Иохан 3:16 бидэнд мэдрүүлдэг билээ. Түүнчлэн Тэр өөрийнхөө хайр болон ивээлүүдээ Есүсийг яг хэрхэн хайрлаж, ивээснийхээ адил бидний амьдралд буулгахыг хүсдэг юм. Иохан 5:20-д *«Эцэг Хүүгээ хайрладаг бөгөөд Тэр Өөрийн хийж байгаа бүхнийг Түүнд үзүүлдэг (харуулдаг) Та нарыг гайхуулахын тулд тэдгээрээс ч агуу ажлуудыг Тэр (Түүнд харуулна) Түүнд үзүүлнэ»*.

Бурхан «Би энэ бүх агуу зүйлсийг Есүсээр дамжуулан хийж байна. Та нарыг гайхуулахын тулд Би Түүгээр дамжуулан үүнээс ч агуу зүйлсийг хийх болно» (миний үг) гэж энд хэлж байна. Бурханы хийж буй ажлуудаас сүрдэх, Түүнийг шагшин гайхах нь зөв зүйтэй зүйл гэдгийг та мэдэх үү.

Бид эдгээр эшлэлийг уншдаг, харин Бурхан бидний төлөө юу хийхийг хүсэж байгааг тэр бүр олж харж чаддаггүй. Бидний Есүсээр дамжуулан хийсэн агуу ажлуудыг Тэр хараад «Таны хийсэн зүйл үнэхээр гайхамшигтай» гэж гайхан шагшираасай гэж хүсдэг. Иохан 14:12-т Есүс *«Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хий-*

дэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэг-тээ очно» гэж хэлсэн.

Бурхан өдөр бүр хүмүүсийн төлөө маш олон зүйлийг хийдэг. Учир нь Тэр тэдэнд хайртай. Гэсэн хэдий ч тэд үүнийг нь хэзээ ч олж хардаггүй.

Та түр азнаад, энэ тухай эргэцүүлэн бодоорой. Нар өдөр бүр манддаг, энэ нь таны болон миний төлөө юм. Хээрийн цэцгийг хүртэл биднийг баяр хөөртэй байлгахын төлөө өнгө өнгөөр дэлбээлүүлдэг. Тийм ч учраас Бурхан энэ дэлхийг бидний төлөө туйлын гайхамшигтайгаар бүтээсэн. Эхлэл 1-р бүлэгт Бурхан хүнд бүх эрх мэдлийг өгч, газрыг эзэмшиж, бүх баялгийг ашиглаж надад үйлчил гэсэн.

Түүнчлэн таны төлөө бороо орж, таны төлөө цас будардаг. Тэрээр таны алхам бүрийг чинь төлөвлөсөн бөгөөд үргэлж хамгаалж байдаг.

Дээд хууль 7:9-д *«Тиймээс чи мэдэж ав. Чиний Бурхан ЭЗЭН бол Бурхан, Тэр бол итгэмжит Бурхан. Тэр Өөрийг нь хайрлаж, тушаалыг нь дагагчдад мянган үеийг хүртэл гэрээгээ сахиж, хайр энэрлээ үзүүлдэг».*

Бурхан биднийг үүрд мөнх, ямар ч болзолгүйгээр хайрладаг. Тэр мөнхөд оршигч Бурхан учраас та Түүнийг залхааж чадахгүй. Бидний замбараагүй амьдрал, алдаа дутагдлаас Бурхан залхаж байгаа гэж олон хүн боддог. Харин үүнээс болж Тэр хэзээ ч залхаж ядардаггүй. Хайр хэзээ ч залхдаггүй, тиймээс та өөрийг тань хайрлах Бурханы хайрыг юу ч хийж байсан хамаагүй хэзээ ч хорьж дийлэхгүй. Хайр гэдэг, Бурханы хийдэг зүйл биш, харин хайр гэдэг Бурхан Өөрөө юм.

Энэ дэлхий дээрх хамгийн адгийн, ялзарсан нэгэн нүгэлтэн Бурханд «Надад чамтай яриад байх юм байхгүй. Би тамд орохдоо үнэхээр сэтгэл хангалуун байна» гэж хэлсэн ч гэсэн, Бурхан түүнийг хайрласаар байдаг. Бурханы зорилгын төлөө сонгогдож, Түүний төлөө тусгаарлагдсан хүмүүсийг Тэр хайрлахгүй байж чадна гэж үү (Дуулал 103:10–13 үз).

Магадгүй та «Би Есүсийг зүрх сэтгэлдээ хүлээн авсан. Би Түүнд хайртай» гэж хэлж болох юм. Тэгвэл би танаас нэг зүйл асууя «Бурхан танд хайртай гэдэгт та хэр итгэлтэй байдаг вэ?»

Бурханы мөнхийн, болзолгүй хайрын үндэс суурийг энгийн үгээр дамжуулъя, та бусад

өөр зүйлсийг ойлгохын тулд Түүнийг амьдралдаа оруулах хэрэгтэй. Эдгээр нь бидний амьдралын эдгэрлийн эхлэл гэдэгт би итгэдэг.

Та Бурханы зүйлсийг эрэлхийлж, Үгийг шамдан судалж, их зүйлд суралцаж байсан ч хамаагүй, хэрэв Бурхан танд хайртай гэдгийг хүлээж авч чадахгүй байгаа бол та нэг их хол явахгүй (Галат 5:6 үз). Тиймээс бид Бурханы хайрыг хүлээн аваагүй бол бид өөр ямар ч зүйлийг хүлээн авч чадахгүй. Бурханы хайр нь биднийг айдасгүйгээр амьдруулж чадна, энэ нь амьдралаа баяр хөөртэй болгох амин чухал зүйл (1 Иохан 4:18 үз).

Таны төлөөх Түүний хайрыг та хүлээж авах уу?

Хайрыг та сайн ажилласнаараа худалдаж авах боломжгүй, зарагддаггүй зүйл бөгөөд зүгээр л танд зориулсан хайр тиймээс та хүлээж аваарай, хүлээж аваарай, хүлээж ав.

БИ ХАНГАЛТТАЙ САЙН БАЙЖ ЧАДДАГ БИЛҮҮ?

«Найдвар нь урам хугалдаггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг. Биднийг сул дорой (өөртөө туслах чадалгүй) байх үед, Христ тогтоосон цагт бурханлаг бус хүмүүсийн (төлөө) өмнөөс үхсэн билээ. Зөвт хүний төлөө хэн нэгэн хүн бараг үхэхгүй. Харин сайн хүний (өөрийнхөө) төлөө бол хэн нэгэн хүн үхэхээр зүрхэлж магадгүй юм. Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ (Мессиа, Тослогдсон Нэгэн) бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. Тиймд

эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн
(цагаатгагдсан, зөвт болгогдсон, эрх
чөлөөтэй болгосноор Бурхантай зөв
харилцаатай болсон) бид тэр тусмаа
Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч
аврагдах (энэ нь тодорхой) болно.
Учир нь хэрэв бид дайснууд байхдаа
Хүүгийнх нь үхлээр Бурхантай
эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа
(тодорхой) бид Түүний амиар авраг-
дах (өдөр бүр нүглийн боолчлолоос
чөлөөлөгдөх) болно».

— РОМ 5:5–10

Алдаж онохгүй, зөв байх үед л Бурхан бид-
нийг хайрладаг гэж олон хүн боддог. Үүнтэй
холбоотой гол асуудал бол маш олон хүмүүс
өөртөө дургүй бөгөөд энэ байдал нь тэдгээр
хүмүүст нөлөөлөхдөө Бурхан тэдэнд бас тийм
ч дуртай биш байх гэсэн бодлыг төрүүлдэг.
Гэтэл Библид «Хүн гэгч юу болоод Та түүнд
санаа тавиж» гэж хэлсэн байдаг (Дуулал 8:4).
Бид бол ердөө л Бурханы бүтээл харин Тэр
бидэнд хайртай учраас биднийг хайрладаг.

Бурхан бол хайр мөн (1 Иохан 4:16 үз). Бурхан биднийг хайрладаг учир Тэр ингэж хүсдэг.

Тэр танд хайртай, яагаад гэвэл та бол онцгой нэгэн. Өөрөөр хэлбэл та давтагдашгүй цорын ганц бүтээл билээ. Таныг надтай, харин намайг тантай адилхан байхаар бүтээгээгүй юм. Хэрэв бид хэн нэгэнтэй адилхан байхыг хичээх юм бол тун амархан сэтгэлээр унах болно. Бид ийнхүү хичээснээрээ, чи бол «хангалтай сайн» хүн биш гэж хэлэх боломжийг дайсандаа олгодог. Таны бүх зүйл Бурхантай хамт байхад заавал «тийм сайн» байх албагүй.

Таныг гайхалтай сайн хүн байсан учраас Есүс таны төлөө үхсэн үү эсвэл Тэр танд хайртай учраас таны төлөө үхсэн үү? (Ром 5:8–9 үз) гэж Библид хэлдэг. Өдөр тутам гаргадаг жижигхэн алдааг чинь халхлахад Түүний хайр хангалттай бөгөөд бүх шударга бус байдлаас чинь таныг цэвэрлэх болно.

Бурхан бидний алдааг хэрхэн хардагаа нэг өдөр надад харуулсан юм. Гэртээ ээжтэйгээ байдаг гурав, дөрөв орчим насны бяцхан охин байна гэж төсөөлье. Ээж нь өдөр бүр гэр орноо цэвэрлэж, тоос шороогоо арчина. Охин ээждээ маш их хайртай учир цонхоо

угааж түүнд туслахаар шийджээ. Тэгээд жижигхэн хувинд ус хийгээд, даавууны өөдсөөр цонхныхоо шилийг зүлгэж, цаасаар арчив. Гэхдээ ийм насны бяцхан охин цонхыг ямар хэмжээнд цэвэрлэх нь ойлгомжтой. Саванг нь арилгалгүй, халтайлгаж орхисон цонхыг харсан хэний ч уур хүрнэ. Гэтэл охин ээж рүүгээ хүрч ирээд хөөрхөн шингэн хоолойгоор «Ээж ээ, ээж ээ би танд цонх угааж өгсөн. Танд туслах гээд цонхоо ийм гоё болгосон. Ээж ээ, би танд хайртай» гэж хэлнэ.

Тэгэхэд нь хайртай ээж нь «Хөөх, миний охин ямар мундаг юм бэ. Ээждээ тусалсанд баярлалаа» гэнэ. Тэгээд охиноо өөр ямар нэг юмаар оролдож эхлэнгүүт түүний завааруулсан зүйлийг цэвэрлэж, дараа яаж зөв сайн хийхийг зааж сургаж, тусалж ойлгуулна.

Бурхан бас бидэнд үүний адилаар хийдэг. Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст тохиолддог бүхий л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг гэдгийг бид мэднэ (Ром 8:28 үз).

Бурхан танаас юуг найдан хүлээдэг вэ гэвэл таныг бүх зүйлд сайнаар хандан юуг яаж хийхээ мэддэг байгаасай гэж хүлээдэг. Түүнчлэн та цааш нь үргэлжлүүлэн хичээн

хийгээд байвал Тэр таныг өсөж хөгжихөд тань тусалж чадна. Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг (2 Коринт 3:18 үз).

«Бурханаас илгээгдсэн Тэр Бурханы үгийг (Бурханы Өөрийнх нь мэдээг тунхагладаг) айлддаг. Учир нь Бурхан Сүнсийг хэмжээлшгүйгээр өгдөг. Эцэг нь Хүүгээ хайрлан, Түүний гарт (итгэж, хийлгэхээр) бүх юмсыг өгсөн юм» (Иохан 3:34–35).

Нэг удаа Библи судлалынхаа цагаар энэ эшлэлийг тунгаан бодож байхдаа Бурхан бидэнд Өөрийн Ариун Сүнсийг хэмжээлшгүйгээр өгснийг ухааран, баярласнаасаа болж би уйлсан. Тэр бидэнд үүнээс багаханыг, түүнээс хумсын төдийхнийг ч өгдөггүй. Харин Тэр өгөөмөр бөгөөд хэмжээлшгүй элбэг дэлбэг, бялхсан бүхнээс дээгүүрхийг өгдөг (Ефес 3:20 үз).

Дэд хууль 7:6–7-р эшлэлд Бурхан *«Та нар бол өөрсдийн Бурхан Эзэнд ариун ард түмэн мөн. Эзэн Бурхан чинь энэ дэлхий дээр байгаа бүх ард түмнүүдээс та нарыг Өөрийнхөө*

өмчлөлийн ард түмэн болгон сонгосон билээ. Та нар бусад үндэстнээс олон байсан учраас Эзэн та нарыг хайрлаж, сонгосон юм бус. Та нар бол бүх үндэстнээс хамгийн цөөхөн нь билээ» гэж хэлсэн байдаг.

Үүнийг бид өөрсдөдөө хандуулах аваас «Та нар юм болгоныг зөв хийдэг болохоор, эсвэл та нар өөртөө хангалттай сайн байсан учраас Би та нарыг сонгосон юм биш», «Мөн та нар сайн учраас биш, харин Би та нарыг хайрласан учраас та нарыг сонгосон» гэж Бурхан хэлж байна. Бурхан таныг өнөөдөр юу хийгээсэй гэж хүсэж байгааг та мэдэж байна уу? Тэр таныг Өөрийнх нь хайрыг хүлээж аваасай гэж хүсэж байна.

Бидний ихэнхэд маань байдаг хамгийн том асуудал бол бид өөрсдөдөө сэтгэл дундуур байдаг явдал юм. Бурхан биднийг хайрладаг гэдэгт бид итгэдэггүй. Эсвэл хэн нэг хүн бидэнд хайртай гэдэгт бид итгэж чаддаггүй. Над шиг ийм дүүрчихсэн хүнийг хэн хайрлах вэ дээ? гэж бид боддог. Хэрэв та өөрийгөө муухай, зэвүүн хүн гэж бодох юм бол аливаа юманд тийм л байдлаар хандана. Та өөрийгөө зүрх сэтгэлдээ төсөөлөн бодож байгаагаасаа хэтэрч чадахгүй.

Миний хувьд хамгийн том асуудал бол би өөртөө үргэлж сэтгэл дундуур явдаг байсан. Жишээлбэл: Би өөрийгөө хэтэрхий яриа хүн гэж бодсон учраас амаа хамхих гэж хичээж эхэллээ. Гэтэл би дуугаа хурааснаар яваандаа сэтгэлийн дарамтад орж, хүмүүс миний энэ хачин чимээгүй байдлын учрыг олох гэж сонирхох болов. Тэгэхэд нь би «Та нар намайг задгай амтай гэсэн биз дээ. Намайг ганцааранг минь орхиодох. Би зүгээр л дуугүй байх гэж хичээж байна» гэж хэлсэн.

Хэдэн жил ийм байдалтай явснаа би та нарт хэлж чадахгүй. Учир нь би өөрөө өөрийгөө өөрчлөхийг хичээж байсан. Одоо ч гэсэн би энэ тал дээр асуудалтай хэвээрээ л байна. Түүнчлэн ийм байдал тохиолдох бүрт намайг ямар муу хүн бэ гэдгийг маань муу сүнс сануулахдаа үргэлж бэлэн байдаг байсан шалтгаан нь тэр биднийг өөрсдийнхөө буруутай болон ялтай байдлаа мэдэрч байгаасай гэдгийг төлөө шаргуу ажилладаг. Тиймээс та ямар нэгэн буруу зүйл хийсэн үедээ Бурхан танд хайртай гэдэгт итгэх явдал нь танд нилээд амаргүй байж болохыг би ойлгодог.

Бурхан таныг буруутгалаас ангид байгаасай гэж хүсдэг. Харин ийнхүү ангид байхын

тулд биднээс итгэл ба зориг гарах учиртай. Та өөрийгөө хичнээн ч буруутгаад буруу хийсэн зүйлсийнхээ ядаж нэгийнх нь төлөөсийг ч төлж чадахгүй гэдгээ мэддэг үү? Би үүнийг дахин хэлэхийг хүсэж байна Та ямар нэгэн буруу зүйл хийсэн үедээ Бурхан танд хайртай гэдэгт итгэх явдал нь таны хувьд нэлээд амаргүй байж болно. Өөрийгөө муу муухай, зэвүүн хэмээн үзэн ядах бодлоор диавол чамайг зай завсаргүй бөмбөгдөнө. «Чи дөнгөж сая тэгээ биз дээ. Чи өөрийгөө хэн гэж бодоод байгаа юм бэ? Чам шиг ийм балиар хүнийг Бурхан хэзээ ч ерөөхгүй. Есүсийн талаар хэнд ч хэлж чадахгүй. Чамд хийж чадах зөв юм нэг ч байхгүй» гэж тэр хэлдэг.

Харин Бурханд итгэх итгэл болон таны дотоод хүн зоригтой бол та «Аав аа, би алдаа гаргасан. Намайг уучлаач хэмээн Есүсийн цусыг барин би Танаас гуйж байна. Таны өршөөлийг чин сэтгэлээсээ хүсэж байна. Диавол аа, чи сүржигнэхээ боль. Есүс миний нүглийн төлөөсийг хэдийнээ төлсөн. Тиймээс энэ чамд огт хүртээлгүй зүйл» гэж хэлж чадна. Бурханы үгийн хүч чадал таны амьдралд хэрэгжих нь Түүнд итгэх таны

итгэл найдварыг чинь өсгөдөг. Тэгсэнээр та өөрийнхөө амьдралд сэтгэл хангалуун байж чадах бөгөөд бусад хүмүүст ч гэсэн нэгэн ивээл болж чадна. Та магадгүй ингэж бодож байж болох юм «Яах гэж би нэг л тэнэг зүйлийг ахин дахин хийгээд байгаа юм бэ?» гэсэн бодол төрж байж болох юм. Би ч бас тийнхүү буруутгагдахаа болих хүртлээ тэгж боддог байсан. Тухайн зүйлээр буруутгагдахаа болих үед та тэр зүйлийг хийхээ болино. Буруутгал ба гэм буруу нь таныг доош дарж, гутралд оруулан, улмаар та эрх чөлөөгүй болдог. Тийм учраас та ялыг эсэргүүцэх Бурханы уучлалын бэлгийг хүлээн авахдаа зоригтой байх ёстой. Та зоригтой байж Бурханы үгэнд юу гэж хэлснийг итгэлээрээ хүлээн авч хөл дээрээ зогсоод буруутгалын эсрэг ҮГҮЙ гэж хэлэх хэрэгтэй. Диавол чамд «Үүнд сэтгэл чинь огтхон ч эмзэглэхгүй байна гэж үү? Ядахдаа хэдхэн цаг ч гэсэн эмзэглэмээр юм даа. Чи маш муухай юм хийсэн шүү дээ» гэж хэлэх үед та «Үгүй, огтхон ч үгүй. Миний сэтгэл огт зовохгүй байна» гэж хэлээд Бурханаас тусамж гуйн залбирснаар Түүний нигүүлээр та буруутгалаас салах болно. Эхний

хэдэн удаа танд мэдээж хэцүү байна. Гэхдээ их л болж гурав, дөрвөн тохиолдлын дараа та хэрхэхээ ухаарч эхлэх болно.

Исаиа 53-т, Есүс бидний төлөө бидний нүглийг үүрсэн бас халхалсан (энэ буруутгалыг ч бас Өөртөө авсан) гэж хэлдэг. Харин диавол таныг энэ буруутгал дор үргэлж боолчлогдож байгаасай гэж хүсдэг. Яагаад? Яагаад гэвэл хэрэв та буруутгалыг мэдэрч байгаа бол Бурханы хайрын илчинд дулаацаж чадахгүй Буруутгал таныг Бурханаас холдуулж, Бурхан та хоёрын дунд хана босгодог. Гэм буруугийн зам дунд зогсож байхдаа та Бурхан Эцэгийг харж чаддаггүй. Харин та өөрийн чинь өмнө байгаа гэм буруу, нүглийг л харсаар байдаг.

Миний нигүүлсэл чиний гэм нүглийг хүртэл далдлахад хангалттай гэж Бурхан хэлсэн.

Түүний энэ үгэнд итгэж, буруутгалаас ангид амьдар. Тэр танд хайртай бөгөөд Түүний нигүүлсэл ба уучлал нь танд зориулсан үнэгүй бэлэг юм. Өнөөдөр та эдгээр бэлгийг хүлээн ав!

ХАЙР БОЛ ХАРИЛЦАА МӨН

«Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж (ойлгож, удирдуулж, ухамсарлаж, туршлагажиж) итгэдэг (итгэл найдвартай дагаж, итгэл найдвараа тавина). Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна».

— 1 ИОХАН 4:16

Библид хэлсэнээр Бурхан бол хайр бөгөөд Тэр биднийг Түүний хайрыг ойлгож, мэдэрч, ухамсарлахыг хүсдэг юм. Хэрхэн Бурханы хайранд илүү мэдрэмтгий, илүү сэргэг байх вэ? Тэр таныг хичнээн их хайрласан ч хэрэв

та үүнийг нь мэдэхгүй, анзаарахгүй бол ямар ч үр дүнгүй байх болно. Хэн нэгэн хүн таныг хайрлаж байгаагаа илэрхийлэх үед танд үнэхээр сайхан санагддаг. Мөн энэ хайрыг мэдрэх үедээ илүү итгэл дүүрэн болдог. Бурхан танд хайртай бөгөөд энэ хайраа танд харуулахыг хүсдэг. Үргэлж Өөртэй нь хамт цаг өнгөрөөдөг байхыг Тэр танаас хүсдэг. Та Бурхантай хувьчлан цаг өнгөрөөдөг үү? Бид дахин төрөх үедээ автоматаар хувьчилсан харилцаатай болдоггүй. Та олон жилийн өмнө авралыг хүлээн авсан байлаа ч энэ нь таныг Бурхантай баялаг харилцаатай гэдгийг илэрхийлэхгүй. Бид түүнтэй харилцах харилцаагаа хөгжүүлэх нь аливаа хүнтэй харилцах харилцаагаа хөгжүүлэхтэй адилхан юм. Би анх Христэд итгээд бүтэн сайн өдөр сүмд яваад түүнд үйлчилж хамт алхаж байсан ч Бурхан миний амьдралын төв байгаагүй бас надад хоосон мэт мэдрэмж төрж байсан.

Харин одоо бол би өглөө нүдээ нээгээд хамгийн түрүүнд Бурханыг боддог. Мөн өдрийн төгсгөлд, унтахаасаа өмнө би Бурханыг л боддог. Түүнчлэн би бүхэл өдрийн турш Бурханы тухай боддог. Энэ дэлхий дээр Бурханд үйлчилж, Түүнийг баярлуулахаас өөр

би юуг ч хүсдэггүй. Үүнээс өөр үнэ цэнэтэй зүйл үгүй.

Бидний дотор Бурханы гаргасан орон зай байдаг бөгөөд зөвхөн Бурхан л тэр зайг дүүргэдэг. Түүнээс өөр юу ч энэ зайг дүүргэж чадахгүй. «Би үүнийг аль хэдийн мэднэ. Би Есүсийг хүлээж авсан» гэж та хэлж болох юм.

Гэвч та Түүнийг өдөр бүр, хором тутамд, бүхий л нөхцөл байдалд хүлээн авдаг уу? Та Бурханы хайрыг хүлээж авч байна уу? Тиймээс таныг өөрөө өөрөөсөө асуугаарай гэж би уриалж байна. Үйлс 17:28-д Паулын хэлсэн шиг «бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог» гэж хэлж чадах уу?

Бурхан танд хайртай. Түүний хувьд та онцгой нэгэн билээ. Тэр биднийг Өөртэйгөө нөхөрлүүлэхийн тулд бүтээсэн. Энэ бол Түүний хамгийн агуу хүслийн нэг бөгөөд таны амьдралд зориулсан Түүний төгс хүсэл юм. Тэрээр өглөө бүр хаан сэнтийнээ тэргүүнээ мэхийлгэн «Өглөөний мэнд, Би чамд хайртай» гэж хэлдэг. Харин та Түүнийг сонсоогүй байхдаа итгэдэг үү?

Найз маань залбирч байхдаа нэг үзэгдэл үзсэн тухайгаа ярьсан юм. Өглөө хүмүүсийн босох цагаар Эцэг Бурхан Америкийн айл

өрхүүдээр явж байх юм гэнэ. Тэрээр тэдэнтэй нөхөрлөж, ярилцахад бэлэн байна. Айлд ороод ширээнийх нь ард сууна. Хүмүүс босож, ширээндээ сууна, тэгснээ босоод явна. Ирээд л, яваад л, ирээд л, яваад л. «Бурхан дараа больё. Та наанаа жаахан хүлээж бай тэгэх үү. Би энэ ажлыг хийж дуусмагцаа Тантай ярилцъя. Дараа нь Тантай нөхөрлөх цаг гаргая. Дараа больё. Дараа нь за» гэж тэд хэлж байжээ.

Өдрийн төгсгөлд урам нь хугарч, тэргүүнээ гудайлган айлаас гарч яваа Бурханыг хараад зүрх сэтгэл нь хичнээн өвдсөн тухайгаа найз маань ярьсан юм. Тэр өдөр хэн ч Түүнтэй ярилцахаар ирээгүй аж.

Хэтэрхий завгүй ажиллах хэрэггүй. Хэрэв танд залбирах, Бурхантай хамт өнгөрөөх цаг гарахгүй байгаа бол та хэтэрхий завгүй байна.

Бурханд ямар их хайртайгаа хэлэх цаг гарга. Бүх юм өнгөрөн одоход зөвхөн Бурхан л үлдэх агаад тэр үед баярлалдан хашхирах чимээ дүүрэн байх болно. Тиймээс хэрэв та Бурхантай харилцдаггүй бол энэ баяр хөөрийг арай хожуу мэдрэх болно. Аав маань саяхан нас барсан бөгөөд тэрээр нас барахаасаа гур-

ван жилийн өмнө Есүсийг Аврагчаа болгон хүлээн авсан тухай хэлэхэд баяртай байна. Гэхдээ аав минь тэнгэрт очсон ч, Бурхантай хамт ялалттай байх баяр хөөрөө алдсан юм.

Учир нь тэр үргэлж өөрийнхөө төлөө амьдарч байсан. Амьдралынхаа төгсгөл хүртэл харамсах зүйлтэй бүү бай. Гэхдээ энэ нь таныг диваажинд очихгүй гэж хэлж буй хэрэг биш, харин та ялалттай амьдрахын баяр хөөрийг мэдэхгүй өнгөрнө гэсэн үг юм. Цаг бол Бурханаас ирсэн үнэ цэнэтэй бэлэг бөгөөд бид бүгдээрээ яаж зарцуулж байгаадаа маш болгоомжтой хандах хэрэгтэй. Нэгэнт өнгөрсөн цаг хугцаа дахин ирэхгүй. Иймд бусад олон зүйл өндөр үнээр ирдэг ч сэтгэл ханамжийг өгч чаддаггүй. Харин Бурхантай хамт цагийг гайхамшигтайгаар өнгөрүүлээрэй.

Өөрийнхөө хүчээр итгэлээр үйлдэх гэж, мөн Бурханы итгэлтэй, хүчтэй хүн байх гэж хичээхээ боль. Харин үүнийхээ оронд бяцхан хүүхэд адил бай. Бурхан Эцэгийнхээ өвөр дээр эрхлэн мөлхөж, таныг хайрлах боломжийг Түүнд олго. Өөрийг тань хайрлах боломжийг Түүнд олгох хүртлээ та Түүнийг эргүүлэн хайрлах боломжгүй юм. Иймд таныг ирэх жилд Бурханы хайранд анхаарлаа хан-

дуулж, хайрын тухай эшлэлүүдийг судлахад цаг заваа зарцуулах шийдвэрийг гаргаасай гэж би хүсэж байна тэгвэл та Түүний хайрыг хэрхэн хүлээн авахыг сурч чадна.

1 Иохан 4:16-д, «*Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж* (ойлгож, удирдуулж, ухамсарлаж, туршлагажиж) *итгэдэг* (итгэл найдвартай дагаж, итгэл найдвараа тавина). *Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна*».

Та өглөө босоод Бурхан танд ямар их хайртай болох талаар боддог уу? Өглөө сэрсэн даруй юу ч хиймээргүй юм шиг санагддаг. Харин та махан биеэ идэвхжүүлж, сүнсээ сэргээн, бүхий л төрлийн гайхамшигтай зүйлсийг хийхийн тулд амаа ашиглах хэрэгтэй.

Иймд бидэнд байгаа сайн мэдээ бол та өглөө босоод өөрийгөө урамшуулан чангаар, «Өө, Аав аа, намайг ингэж хайрладагт тань баярлаж байна. Миний төлөө Есүсийг явуулсанд баярлалаа. Аав аа, надтай хамт Ариун Сүнсээ байлгаж байгаагийн төлөө баярлалаа. Таны дахин амилсан хүч миний дотор байгаагийн төлөө Танд талархаж байна. Өө, Эзэн, өнөөдөр явсан газар бүрдээ ерөөл болж бай-

гаагийнхаа төлөө Танд баярлалаа. Бурхан, Та надад хайртай. Та намайг яг энд, энэ бяцхан гэрт минь хайрладаг. Тийм ээ, Та надад хайртай! Би таны онцгой хүүхэд билээ. Би бол Таны нүдний цэцгий. Та надад хайртай!» гэж хэлэх хэрэгтэй. Явсан газар бүрд чинь Бурханы хайр таныг хучиж байгаа гэдгийг ухаарч, үүнийг өөртөө байнга хэлж занших хэрэгтэй. Бурхан биднийг алгандаа сийлсэн гэж Библид хэлдэг (Исаиа 49:16 үз). Би Бурхан уруу харахдаа «Үүнийг харж байна уу? Тэр үнэхээр хөөрхөн байгаа биз дээ? Би түүнд маш их хайртай. Алган дээр минь байгаа Миний хүүхдүүдийг хар л даа» гэж хэлж байгааг нь олж хардаг. Тэр таныг хайрлаж, таньтай нөхөрлөхийг хүсэж байгаагаа илэрхийлэн таныг алгандаа байлган харж байдаг.

Бурханд талархаж, Түүнтэй харилцах харилцаагаа улам бүр хөгжүүлэхээ бүү мартаарай. Заримдаа та Бурханы өмнө сөхрөн, аврагдсаныхаа төлөө Түүнд талархах хэрэгтэй. Тэр бол амар тайван ба хайр. 1 Иохан 4:16–17-д хэлэхдээ, «...Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна. Үүгээр (Түүнтэй эвлэрэх, нэгдэх) шүүлтийн өдөрт

биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов».

Бурхан таныг хайрладаг гэдгийг мэдэх нь танд итгэлтэй байдлыг өгөх ба та Түүнд бүрэн итгэж, Түүний итгэмжит байдалд бүрэн найддаг болно. Өөрийг тань хайрлах боломжийг Бурханд тавьж өг. Тэгвэл үүгээр дамжуулан илүү их итгэл, эдгэрэл, хөгжил цэцэглэлт, баяр хөөр нүглийг ялах ялалт гээд бүх ерөөл ирэх болно. Бид ихэнхдээ үүнийг урвуугаар нь ойлгож «Би Бурханд хайртай» гэж хэлдэг. Харин та эхлээд өөрийг тань хайрлах боломжийг Бурханд тавьж өгөх хэрэгтэй гэж би боддог. Түүнд ийм боломжийг өгөөгүй байж өөрийнхөө хайрыг илэрхийлэх боломжгүй юм. Библид хэлэхдээ, *Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг юм* (1 Иохан 4:19 үз).

Бурхан бидэнд хайртай гэдгийг бид мэдэж Түүний хайрыг хүлээн авах үедээ л бид хариуд нь Түүнийг хайрлаж чаддаг. Тэгсэнээрээ бид Түүнтэй нөхөрлөж чадна. Та магадгүй асууж байж болох юм Бурхантай би хэрхэн нөхөрлөх вэ? Бурхан надад энэ үгийг хэлэх үед би буйдан дээрээ суугаад «Бурхан, би одоо юу хийх вэ?» гэж асуусан. Тэр надад хэр

зэрэг хайртайг нь би үнэндээ мэдэхгүй байсан учраас хэрхэн нөхөрлөхөө мэдэхгүй байсан юм. Тэр намайг Өөрийн найз, байнгын хамтрагч байхыг хүсдэг. Би Түүнтэй хамт цагийг өнгөрөөж, залбирч, Үгийг уншиж, заримдаа Түүний дэргэд нам гүм байх үед Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийг хэрхэн эхлэх талаар суралцсан юм.

Би таныг алхам хийж эхлээсэй гэж хүсэж байна. Бурханд боломж өг, Тэр та нарт хэрхэн нөхөрлөх талаар зааж өгөх болно. Би танд нэг, хоёр, гурав гэх мэтийг зааж, Бурхантай хэрхэн нөхөрлөх талаар ямар нэг заавар өгмөөргүй байна. Харин би та нарыг Түүний Ариун Сүнсээр удирдуулахыг хүсэж байна. Бурхан та нарыг Түүнтэй хамт амар тайван байлгахыг хүсдэг... Ефес 3:17-д бичсэний дагуу таны зүрх сэтгэл Христийн гэр юм.

ХАЙР, НАЙДВАР, ИТГЭЛ

«Христ Есүс дотор (бидэнд) хөвч хөндүүлэх ба хөвч хөндүүлэхгүйн аль аль нь ямар ч ашиг тусгүй. Харин хайраар дамжуулан ажиллаж буй итгэл л чухал юм».

— ГАЛАТ 5:6

Ихэнх хүмүүс итгэлтэй байх гэж хичээсээр маш их цаг алддаг. Итгэлгүйгээр Бурханд таалагдах боломжгүй (Еврей 11:6 үз) гэдгийг бид мэддэг учраас илүү итгэлтэй болох гэж тийнхүү хичээдэг. Гэтэл итгэл гэдэг зүрх сэтгэлтэй холбоотой учраас бидний зүрх сэтгэлд өсөж хөгждөг ба түүнийг Бурхантай нөхөрлөх хайрын харилцаагаар л дамжуулан авч

чадна. Би танд итгэлийг зааж чадахгүй, харин итгэлийн зарчмуудыг зааж, түүнийг олж авахын тулд юу ч хийхэд бэлэн болтол чинь түүгээр өлсгөж чадна. Итгэл нь зөвхөн Бурханы илчлэлтээр ирдэг.

Итгэлтэй байх, Бурханд таалагдах гэж тэгтэлээ хичээхээ болиод, үүнд зарцуулдаг цагаа Бурхантай хамт байж, Түүнийг хайрлахад зориул. 2 Коринт 5:7 хэлэхдээ, *«Учир нь бид үзэгдэж байгаагаар бус, харин итгэлээр алхаж байна (бид амьдралаа хэрхэн удирдаж, өөрийгөө хэрхэн авч явах нь Бурхантай болон бурханлаг зүйлстэй өөрийгөө ямар харилцаатай гэж дүгнэхээс хамаардаг)»*.

Энэ эшлэлийг уншиж байхад Бурхан миний зүрхэнд маш хүчтэй ярьж эхэлсэн юм. Би итгэлээр алхахыг хичээж байна. Бүх зүйл дээр итгэлээр алхахыг үнэхээрих хүсдэг.

Өөрөөр хэлбэл, Бурхантай харилцах харилцаандаа итгэлтэй байгаа цагт л би итгэлээр явж чадна. Та үүнийг ойлгож байна уу? Энэ нь би л өөрөө итгэлээр явахыг хүсээд хичээгээд байгаа зүйл биш юмаа гэдгийг Тэр надад харуулсан юм.

Түүнчлэн өөрийгөө гэм нүгэлд баригдсан, олиггүй этгээд учраас Бурхан түүнийг хайр-

ладаггүй гэж боддог хүн бас итгэлээр алхаж чаддаггүй. Зөвхөн Есүс Христийн золиослоор Бурхантай зөвтгөгдсөн (2 Коринт 5:21 үз). Олон хүн итгэлээр алхах гэж хичээдэг ч дараах зүйлийг зүрх сэтгэлдээ ойлгоогүй байдаг.

Галат 5:6-д, итгэл нь хайраар дамжуулан ажилладаг гэсэн байдаг. Бурхан миний зүрх сэтгэлд ингэж хэлсэн «Хүмүүс дээрх эшлэлийг ойлгохдоо, хэрэв тэд бусдыг хайрлахгүй бол тэдний хайр ажиллахгүй гэж ойлгодог. Гэхдээ энэ буруу ойлголт юм. Харин энэ эшлэлд, Намайг өөрсдөд нь хэр их хайртайг тэд мэдэхгүй бол тэдний итгэл ажиллахгүй гэж хэлж байна». Итгэл нь хайргүйгээр ажиллахгүй. Гэхдээ энэ нь таны бусдыг хайрлах чадварын тухай биш, харин таныг хайрлах боломжийг Төгс Хүчит Бурханд тавьж өгөх тухай юм.

Энэ хоёрын хооронд маш их ялгаа бий. Бурханд найдах, итгэлээр алхах гэдэг нь ямар ч зүйл дээр Бурханаас зуурч, Түүнд найдахыг хэлдэг. Хэрэв тухайн хүн танд хайртай гэдгийг та мэдэхгүй бол түүнд найдаж, түшиж чадахгүй шүү дээ. Иймэрхүү бодол танд төрөх ч үгүй байж болно. Хэрэв та Бурхан танд хайртай гэдгийг мэддэггүй бол хэзээ ч Бурханд найдаж чадахгүй.

Харин Бурхан танд маш их хайртай гэдгийг та үнэхээр мэддэг бол эдгэрлийг хүлээн авахад чинь нэг их асуудал тулгарахгүй. Түүнчлэн санхүүгийн хувьд дэмжлэг туслалцаа авахад чинь асуудал гарахгүй.

Бурхан танд энэ бүхнийг өгч байна гэдэгт та бүрэн дүүрэн итгэдэггүйгээсээ болоод эдгээр ивээлийг хүлээн авч чаддаггүй. «Би үүнд итгэмээр л байна. Гэвч яаж итгэх вэ?» гэж та асууж болох юм.

Бурханы хайр таны дотор хэдийнээ өгөгдсөн. Харин таны хийх ёстой зүйл бол ердөө л Бурхан тэрхүү хайраа үзүүлэх үед түүнийг нь мэдрэх явдал юм. *«Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг юм»* (1 Иохан 4:19) гэж Библи хэлдэг. Бурхан таныг эхлээд хайрласан гэсэн баталгаа танд байгаагүйсэн бол таны хувьд Бурханыг хайрлах боломжгүй байх байсан.

Бурханы хайр таны дотор, таны зүрхэнд өгөгдсөн. Түүний хайр таны зүрх сэтгэлд буй. Бурхан танд хайртай! Та бол гайхамшигтай нэгэн! Та бол үзэсгэлэнтэй! Та бол үнэ цэнэтэй! Та бол агуу! Бурхан танд хайртай! Бурхан

таныг хайрладаг шиг энэ дэлхий дээр хэн ч, хэзээ ч таныг тийнхүү хайрлахгүй.

Бурханаас өөр хэн ч танд хэрэггүй боловч Бурхан таны амьдралд бусад хүмүүсийг өгдөг. Хэрэв Бурхан та хоёроос өөр хэн ч байхгүй байсан бол таны хувьд бүх юм сайхан байх байсан. Бурхан таны хамгийн сайн найз, хань ижил, ээж аав чинь байх байсан. Танд хэрэгтэй бүх зүйл бол Тэр. Өөрийн амьдралдаа хэрэгтэй бүх зүйлээ Бурханаас асуулгүйгээр хийж, өөртөө алдааг бүү хий. Түүнийг бүх биеэрээ мэдэрч, Түүнтэй хамт бүхнээр дүүрэхийг Түүнээс гуй (Ефес 3:16, 19 үз).

Бурхан танд ийм их хайртай. Тийм ч учраас та бүхий л зүйл дээр Түүнд итгэж болно. Тэр танд ийм их хайртай учраас хэрэгтэй зүйлээр чинь хангахыг хүсдэг.

Эдгээр зүйлсийг Өөрийнхөө цаг хугацаа, арга замаар өгөх болно (Дуулал 37:4-ийг үз). Бурхан Абрахамд чамайг би ерөөж, чамаар дамжуулан бусдыг ч бас ивээнэ гэж хэлсэн. Энэ нь Бурханы таны төлөө хийхийг хүсдэг зүйл юм. Итгэхтүн, Бурханы бүх амлалтанд итгэ, учир нь энэ нь та нарын төлөө юм!

Итгэл нь махан биеийн үйлсийг эсэргүүцдэг

Ефес 2:8-д хэлэхдээ «Учир нь нигүүлслээр (Бурханы таалалаар) та нар итгэлээрээ аврагдсан юм...» Та өөрийнхөө авралын төлөө юу ч хийгээгүй гэдгээ мэддэг үү? Есүс биднийг аврах үед бид өмхөрч ялзарсан байсан. Тэрээр биднийг аврахдаа бидний сайн үйлс, аливааг зөв хийх чадвар дээр түшиглээгүй юм. Харин Бурхан биднийг үнэхээр их хайрласан тул цорын ганц хайртай Хүүгээ бидний төлөө үхэлд тушаасан бөгөөд Хүүд нь итгэсэн хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм (Иохан 3:16 үз).

Бурханы нигүүлсэлийг таны амьдралын бүхий л хэрэгцээг хангахын тулд Бурхан Өөрийн чадварыг ашиглахад бэлэн байгаа явдал гэж тодорхойлж бас болно. Авралыг авахад хангалттай итгэлийг Бурхан нигүүлслээрээ танд өгсөн шигээ Өөрийг нь таны эдгээгч гэдэгт итгэх итгэлийг ч бас өгдөг. Учир нь Тэр танд хайртай. Таныг хэрэгцээтэй зүйлээр хангагч нь Бурхан гэдэгт итгэх итгэлийг ч Тэр танд өгдөг. Заримдаа махан биеийн үйлдлүүд, эсвэл бид өөрийн хүч

чадлаараа хийхийг оролддог зүйлс нь, зөвхөн Бурханы хийж чадах зүйл байдаг бөгөөд хийх гэж оролдох үед бидний урам хугардаг. Энэ нь бидэн сайн биш юм. Бидний хийх ёстой зүйл бол Бурханы өмнө даруухан байж, Түүний тусламжийг гуйх явдал юм. Библийн 1 Петр 5:5-д хэлэхдээ «...Учир нь Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлслээ (хүч болон ивээлээ) өгдөг» гэсэн байдаг.

Бурханы нигүүлсэл бидний амьдралд маш чухал билээ. Бид итгэлээр болон нигүүлсэлээр аврагдсаны адил бид өдөр тутмынхаа амьдралд итгэлээр дамжуулан ирдэг Бурханы нигүүлсэлээр амьдрах хэрэгтэй. Бурхан танд хайртай гэдэгт хэрэв та итгэдэг бол, үүнийг үнэхээр мэдэж эхэлсэн бол та Түүнд жинхэнээр найдаж эхлэх болно. Та Бурханы Үг үр жимстэй гэдэгт итгэлтэй байх болно. Бурхан танд хайртай учраас таныг хэзээ ч хуурахгүй гэдгийг та мэдэх болно.

Англи Библийн «Amplified Bible» хувилбарт «итгэл» гэж «Бүхий л бие сэтгэлээрээ Түүнийг түших» [Бурхан] «Түүний хүч, мэргэн ухаан, сайхан сэтгэлд бүрэн найдах»-ыг хэлдэг (Колоссай 1:4). Таныг хайрлах болом-

жийг та Бурханд тавьж өгснөөр Түүнийг хайрлаж, Түүнд найдаж сурах ба тийнхүү та итгэлтэй болно.

АЙДСААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ НЬ

«Хайрын дотор айдас (оршихгүй) байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг (бүрэн, төгс) хөөн зайлуулна. Учир нь айдаст ял байдаг. Айдаг нэгэн бол хайрын дотор төгс (хараахан бүрэн төгс болоогүй) болгогдоогүй байна».

— 1 ИОХАН 4:18

Бурхан бидэнд хайртай гэдэгт итгэж, Түүнд найдаж, итгэлээр алхаж явах үед гэнэт бидэнд дайралт ирдэг. Үнэндээ Бурхан үүнийг хийдэггүй, бид бол Тэр л тэгдэг гэж бодож байдаг. Гэтэл Түүнд төлөвлөгөө байдаг ба илүү сайнаар бодож биднийг бидний хүнд нөхцөл байдлаас салгаж агуугаар өөрч-

лөхийг хүсдэг. Тэр үнэндээ биднийг хүнд зовлонтой нөхцөл байдлаар минь дамжуулан Түүнд итгэх бидний итгэлийг батжуулах ба хэрхэн итгэх вэ гэдэгт суралцахад тусалдаг. Гэвч бид Түүний цаг хугацааг ойлгодоггүй. Аливаа хүнд зүйл тулгарахад амархан сатаны хавханд орж Бурхан биднийг хайрлахаа больсон гэж итгэлээр унадаг.

Харин бид энэ үед Ром 8:35–39 дэх эшлэлийг санах хэрэгтэй, өөрөөр хэлбэл биднийг Бурханы хайраас хэн ч юу ч салгаж чадахгүй бөгөөд бид Есүс Христ дотор ялагчид юм аа гэж байна. Хамгийн сайн зүйл бол бидэнд хэцүү зүйл тулгархад чангаар «Бурхан Та надад хайртайг би мэднэ. Миний төлөө хамгийн сайныг хийдэг гэдэгт итгэдэг» гэж хэлэх хэрэгтэй. Бурхан биднийг хүлээлгэдэг, заримдаа хэтэрхий оройтдог гэж бид боддог. Лазарыг санаж байна уу тэр өвчтэй байсан гэвч Есүс очилгүй байсаар тэр үхсэн, дараа нь очиход Марта Есүст хэтэрхий оройтсоныг нь хэлдэг. Гэвч Тэр хэзээ хэрэгтэй цаг нь вэ гэдгийг мэддэг ба Бурхан бидний цагаар биш өөрийн цагаар ажилладаг билээ. Танд хүнд хэцүү нөхцөл байдал бий болоход Бурханаас нүдээ салгалгүй итгэхээ бүү зог-

соогоорой. Бурхан таныг хайрладаг гэсэн итгэлээ айдас, самууралаар итгэлгүй болгохыг бүү зөвшөөр.

1 Иохан 4:18-д «...*төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна...*» хэмээн тун гайхалтай өгүүлжээ. Би энэ эшлэлийг ойлгох гэж нэлээд удаан бодсон. Гэтэл нэг өдөр Бурхан миний сүнсэнд үүнийг ойлгуулж өгсөн юм. Төгс хайр айдсыг хөөн зайлуулдаг. Харин тэрхүү төгс хайр нь Бурхан Өөрөө аж. Таныг хайрласан тэр хайр ямар төгс болохыг мэдэх үед та юунаас ч айхгүй болно. Хэрэв та Бурханы хайрын илчлэлтийг хувьчилан хүлээн авсан бол та юунаас ч айх учиргүй.

Бурхан танд хайртай гэдгийг та мэддэг бол бүтэлгүйтлээс айхгүй байж чадна. Хэрэв та Бурханд найдаж, Түүнд түшиглэдэг бол бүтэлгүйтлээс ангид байх боломжтой. Харин та өөртөө найдвал бүтэлгүйтэх нь гарцаагүй. Бурхан танд хайртай гэдгийг та мэддэг бол бүтэлгүйтэлээс айхгүй. Бурхан танд хайртай гэдгийг та мэддэг бол хэн нэгэнд гологдоно гэж айхгүй байж чадна.

Бурханы хайр ийм агуу учраас бүхнийг халхалдаг. Таныг аварч, таныг чөлөөлсөн тэр Бурхан таныг буруутгана гэж үү? Сатан бол

буруутгагч. Гэм нүгэлд унах үед чинь Бурхан таныг зэмлэж, түүнээс гарах арга замыг зааж өгдөг. Харин диавол таныг буруутгаж, үүнээс гарах ямар ч зам байхгүй гэж хэлдэг (Иохан 10:18 үз).

Дэлгэрэнгүй Библи, 1 Иохан 4:18-г уншвал «*Хайрын дотор айдас (оршихгүй) байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг (бүрэн, төгс) хөөн зайлуулна. Учир нь айдаст ял байдаг. Айдаг нэгэн бол хайрын дотор төгс (хараахан бүрэн төгс хайр болоогүй) болгогдоогүй байна*».

Өөрийнх нь хайр айдсыг хөөн зайлуулдаг тухай энэ илчлэлтийг Бурхан надад өгсөн дарууд би түүнийг амьдралдаа хэрэгжүүлсэн. Тэр үед миний машины дамжуулах араа доголдсон байсан юм. Нэлээд том дамжуулах араа байсан болохоор бусад эд ангитай нь хамт солиход хангалтай хэмжээний мөнгө байгаагүй. Тиймээс би тэр чигээр нь унасаар л байлаа.

Тэр нэгэн өглөө Бурхан надад «Жойс, бүхий л өдрийн турш зөвхөн Намайг хайрла, бас чамайг хайрлах боломжийг надад өг. Өөр юу ч хийх хэрэггүй. Чи агуу итгэлтэй эмэгтэй байх шаардлагагүй. Чиний хийх ёстой зүйл бол ердөө л Намайг хайрлах, мөн чамайг хайрлах

боломжийг Надад өгөх явдал. Гэхдээ үргэлж шүү. Чамайг хайрлах боломжийг Надад өг» гэж хэлсэн.

Тиймээс би итгэл дотроо зогсон, Бурханыг магтан дуулж, гайхамшигтай цагийг өнгөрөөсөн. Гэтэл 45 минутын өмнө ажилдаа явсан нөхөр маань гаражаасаа ирж байгаа чимээ сонсогдлоо. Нөхөр маань хаалга онгойлгосноо, «Машин 1-р араандаа ерөөсөө ордоггүй. Бид ямар нэг арга хэмжээ авахгүй бол болохгүй нь» гэж хэлэв.

Би инээж гарлаа. Гэхдээ энэ нь тухайн тэр мөчид үүнийг санаатайгаар хийхээр шийдсэн явдал биш байсан. Зүгээр л би, өөрийн эрхгүй инээж байсан. Энэ инээд миний сүнсэн дотроос ундрэн гарч байлаа. Тэр өглөөний турш би намайг хайрлах боломжийг Бурханд тавьж өгсөн учраас тийнхүү инээж байсан гэдгийг Бурхан надад харуулсан. Таныг хайрлах боломжийг Бурханд тавьж өгснөөр таны өмнө итгэлээр алхах хаалга нээгддэг. Би зүгээр л инээж эхэлсэн ба энэ бол итгэл байсан юм.

Абрахамын инээд ч бас итгэлийн илэрхийлэл байсан. Бурхан түүн дээр ирж, хүүтэй болно гэж хэлэхэд тэр инээсэн. Үүгээрээ тэр «Бурхан алдаршиг! Би Таны үгэнд итгэж бай-

на» гэж хэлж байсан юм. Харин Сарагийн инээд эргэлзэл, итгэлгүй байдлын илэрхийлэл байсан учраас Бурхан түүнийг зэмлэсэн. Харин Бурхан Абрахамыг инээснийх нь төлөө зэмлээгүй. Бурхан Абрахамыг инээлээ гэж уурлаагүй. Учир нь энэ бол итгэлийн инээд байсан.

Бид итгэвэл Бурхан гайхалтай үүд хаалгыг нээх болно гэж би итгэдэг. Асуудал гарах үед хэн инээж чадах вэ? *«Тэнгэрт залрагч инээж, Тэднийг Эзэн тохуурхаж байна»* гэж Библи хэлдэг (Дуулал 2:2–4 үз). Хэрэв Бурхан үүнийг хийж чадвал бид ч бас чадна. Яваад инээ, итгэлийн инээдээр инээ. Эцсийн эцэст Бурхан танд хайртай. Хэрэв Бурхан та нарын төлөө байгаа бол хэн таны эсрэг байж чадах билээ?

ХАЙР БУСДАД ХҮРДЭГ

«Бурханыг хайрладаг нэгэн нь мөн ах дүүгээ (итгэгчид) хайрлах ёстой. Бид энэ тушаалыг (дүрэм, захирамж) Түүнээс авсан билээ».

— 1 ИОХАН 4:21

Та бол Бурханы онцгой хүүхэд. Та гойд, тантай адил хүн хаана ч байхгүй (Дэд хууль 7:6 үз). Хэрэв та үнэхээр өөрийгөө Бурханы хувьд онцгой гэдгээ мэддэг бол энэ нь танд урам зориг, баяр хөөр, итгэлтэй байдлыг өгч таны амьдралыг мэдрэх мэдрэмж өөрчлөгдөнө. Та «Бурхан надад хайртай. Миний бүх зүйл сайн байгаа. Би хүмүүст Бурханы хайрыг бэлгэлэж чадна» гэсэн бодлоос болж

байнга инээмсэглэх болно. Та хаана ч байсан аз жаргалтай байх болно, харин таны баяр хөөр бусдад дамжуулагдах болно.

Дуулал 100:2-т «Эзэнд баяртайгаар үйлчил...» гэж хэлсэн байдаг.

Бид өөрсдийгөө хэр онцгой гэдгийг мэдэрч, Бурхан бидэнд хайртай гэдгийг мэдэн, бидний хандлага, зан байдал энэхүү илчлэлт дээр суурилснаар бид Христийн сайн мэдээг хуваалцах чадвартай болж, Түүний хайрыг янз бүрийн байдлаар харуулснаар хүмүүсийг Түүн рүү татдаг.

Таны дотор буй Бурханы хайр таныг айдсаас чөлөөлөх учраас та бусад хүмүүст тэрхүү хайраар хүрэхдээ юунаас ч айхгүй байж чадна. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно гэж Есүс хэлсэн. Түүний энэ үгэнд та нарыг итгээсэй гэж Бурхан хүсдэг. Есүс таны дотор амьдардаг Түүнд итгэлээ өгч таныг Тэр бусад хүмүүсийг хайрлаж туслуулахын тулд хэрэглэхийг хүсдэг гэдэгт итгэ. Бурханы төгс хайр бүх айдсыг зайлуулдаг гэдгийг санаарай. Таны итгэлээрээ хийх гэж буй алхамд чинь ямарч айдас бүү саад болог.

Би хичнээн ч удаа итгэлийн ирмэгт тулж ирж байснаа санахгүй байна. Ямар нэг юм хийх гээд зориг хүрэхгүй, айж зогсох үед Бурхан, «Жойс, Би чамаар дамжуулан агуу ажлуудыг хийх болно. За алив, эхэл» гэж хэлдэг байсан. Тэгэхэд нь би шууд л ханцуй шамлан ордог бөгөөд Бурхан намайг нэг ч удаа эвгүй байдалд оруулж байгаагүй.

Би итгэлийн алхам хийх бүртээ бүтэлгүйтэх вий гэж санаа зовох шаардлага надад байдаггүй. Яагаад гэдгийг та нар мэдэх үү?

Яагаад гэвэл Бурхан надад хайртай гэдгийг би мэддэг. Тэр надад хайртай мөн намайг Өөрт нь хайртай гэдгийг Тэр мэддэг. Түүний нигүүлслээр би амьдралаа Түүнд зориулах болсон. Хэрэв та амьдралаа Бурханд зориулахаар шийдсэн бол та Бурханд хайртай, Бурхан танд хайртай учраас энэ дэлхий дээр таны давж чадахгүй асуудал гэж байхгүй.

Сүнснийхээ хүчийг өөр дээрээ төвлөрүүлэн, өөрийнхөө хэрэгцээг хангахад зарцуулах хэрэггүй. Өөрт чинь хэрэгтэй байгаа зүйлийг Бурханд хэлээд, эсвэл та Түүн дээр анхаарлаа хандуулсан хэвээр байх хэрэгтэй бөгөөд тэгсэнээрээ таныг бусдад хүрч тэдэнд ивээл болоход чиглүүлдэг Ариун Сүнсний арга

замуудад та мэдрэмжтэй хандаж чадна. Тэр үед та өөр хэн нэгний төлөө аливааг хийвэл, Бурхан та нарын төлөө бүхнийг хийх болно. Иймд танд хэрэгцээ, шаардлага гарах үед, «хэрэгцээндээ» биш «оюун ухаандаа» үрийг таридаг байх хэрэгтэй. Энэ нь та бусдад хүрч, өөрийн амьдралдаа хүссэн үрээ суулгасанаар Бурхан таны үр удамд тань ургацыг нь өгөх болно. Бурханы хайр нь бусдын хэрэгцээг эхэнд тавих чадварыг танд өгөх болно. Хайраар дутсан, бусдад үнэлэгддэггүй, уур уцаартай хүмүүсийг хайрлаж, тэдэнд үйлчлэх чадварыг Бурханы агуу хайр танд өгсөн гэж та боддог уу?

Танд хайртай хүнийг хайрлахад ямар ч бэрхшээл байхгүй. Үүнд хэцүү юм огт үгүй. Ямар ч нүгэлтэн ингэж чадна. Харин хайрлахад хэцүү хэн нэгэнд хэрвээ та тэвчээртэй хандаж, хайрлахад хэцүү байгаа бол Бурхан таныг хүлээх зуураа таныг үргэлжлүүлэн хайрласаар байсан тэр мөчүүдийг санаж Түүнд таныг өөрчлөх боломж олгоорой. 1 Коринт 13-т хайр бол тэвчээртэй, эелдэг, бардам зан гаргадаггүй, хайр хэзээ ч гоморхдоггүй, амархан гомддоггүй, муутай тооцоо хийдэггүй, гэж байгаа билээ. Бурханы хай-

раар өлсөж, цангаж, хаягдсан хүн бүрт бид Түүний агуу хайрыг түгээн дүүрнээр өгөх явдал юм.

Магадгүй үүнд нэг жил, таван жил, бүр хорин таван жил ч шаардагдаж болно. Хэчнээн ч жил зарцуулсан хамаагүй энэ бол үнэ цэнэтэй үйлдэл юм. Есүс таныг хэр удаан хүлээсэн билээ?

Бурхан танд хайртай. Мөн таны эргэн тойронд байгаа хүмүүст ч бас хайртай. Нүгэлтнүүд ч бай, аврагдагсад ч бай Бурхан бүгдэд нь хайртай. Тэр таныг хайрынхаа суваг болгохыг хүсдэг. Гадагш гарч, хүмүүст үйлчлэхээс бүү ай. Бурханы хайр таныг айдас, буруутгалаас чөлөөлдөг Тэр танд бусдыг хайрлах чадварыг өгдөг. Бурханы хайрыг эргэн тойрондоо түгээн амьдрах шийдвэр гарга. Хүмүүст нөхөрсөг хандаж эхэл. Христийн бие дотор хүмүүст ивээл болж, тэдний өөрсдийнх нь амьдралд нь Бурханы хайрын төлөө үйлчил. Хүмүүсийг гэртээ урь, хамт хоолло. Тэдний гарыг атгаж, инээмсэглэл бэлэглэ. Танаар хийлгэх ажил Бурханд бий. Өөр хэнээр ч биш, зөвхөн танаар хийлгэх ажил Түүнд байдаг. Тэр таныг бусдаас онцгой байдлаар ажиллуулахыг хүсдэг.

Зөвхөн таны хүрч үйлчилж чадах хүмүүс гэж бий. Танаас өөр хэн ч тэдэнд хүрч чадахгүй. Зөвхөн та л тэдэнд хүрч чадна. Тиймээс тэдэнд хэрхэн хүрэх арга замыг Бурханаас асуугаарай. Тэр танд зааж өгөх болно.

БУРХАНЫ ХАЙР ТАНЫГ ӨӨРЧИЛНӨ

*«Бид Бурханыг хайрласан бус, харин
Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн
төлөө Хүүгээ эвлэрүүлэл (цагаатгач
золиос) болгон илгээсэн билээ. Үүнд
хайр байгаа юм».*

— 1 ИОХАН 4:10

Бурхан бидэнд хайртай. Гэтэл бид Түүний хайр ямар агуу болохыг эсвэл Тэр биднийг хэр их хайрладгийг үнэндээ сайн ойлгодоггүй.

Бурхан биднийг ямар их хайрладгийг бид сүнсэндээ үнэхээр мэддэг бол ердийнхөөсөө огт өөр байх байсан гэдгийг энэ номыг бичи-

хээр олон зүйл уншиж судалж байхад маань Бурхан надад харуулсан юм.

Таны төлөөх Бурханы хайрыг үргэлж тунгаан бод. Энэ л таныг өөрчлөх болно. Хэрэв та өөрийнхөө ямар нэг юманд дургүй байдаг бол Бурхан танд хайртай гэдгийг «мэдэж байгаагаа мэдрэх нь» таны энэ байдлыг өөрчлөх болно. Хэрвээ та өөрийнхөө буруу зүйлээ итгэсэн хэвээр байгаад байвал, та хэзээ ч өөрчлөгдөхгүй. Бурхан итгэлээр дамжуулан ажилладаг гэдгийг санаарай, жинхэнэ итгэл нь биднийг Бурханы амар тайванд хүргэдэг (Еврей 4 үз).

Өөрийнхөө талаар таагүй сэтгэгдэл тээж, өөртөө дургүйцэж, өөрийгөө үзэн ядаж, өөрийнхөө ямар онцгой хүн болохыг ойлгохгүй маш олон хүмүүс байдаг. Магадгүй та муу зүйл хийсэн гээд өөрийгөө үзэн ядсан ч гэсэн хэзээ ч өөрийгөө үзэн ядаж болохгүй. Учир нь Есүс танд хайртай бөгөөд таны төлөө амиа өгсөн ба Өөрийн хамгийн үнэ цэнтэй бэлгийг хүлээн аваасай гэж хүсдэг.

Хэрвээ та өөрийгөө бүх цаг үеийн туршид муугаар бодож, үргэлж өөрийгөө үгүйсгэж, онцгой гэж ухаарахгүй байвал, Та Бурханы амар амгалан, баяр баясгалангүй байх болно,

мөн таны хандлага, үйлдлүүд үүнийг харуулах болно. «Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм» (Сургаалт үгс 23:7 үз) гэж Библид хэлдэг. Бурхан танд хайртай гэдгийг мэдэх нь туйлын хүчтэй мэдрэмж юм. Өдөр бүр Өөртэй нь хамт байхыг Бурхан танаас хүсдэг. Тэгсэн цагт та өөрчлөгдөх болно. Хэрэв та Бурханыг нэгдүгээрт тавихгүй бол таны амьдралд хүсэж байгаа зүйлээ хийх боломжгүй байр сууринд Түүнийг тавьж байна гэсэн үг. Бурхантай хамт өнгөрүүлж байгаа цаг чинь хувьчилсан байх ёстой. Тэр цагт та Түүнийг хайрлаж, мөн таныг хайрлах боломжийг Түүнд тавьж өгөөрэй. Тэгснээр та сүнсээр өсөж, таны сүнс хүчтэй болно.

Олон хүмүүс Бурхантай харилцах харилцаа байгуулахгүй байхын тулд шалтаг шалтгаан тоочдог. Тэд Бурхантай бат бөх харилцаатай байхыг хүсдэг ч үүний тулд хичээл зүтгэл гаргаж Түүний үгийг судалж, залбирдаггүй. Хэрэв та мөн ингэж ханддаг бол Бурханаас өөртөө өдөр бүр Түүнтэй цагийг өнгөрөөх зуршилтай болгож өгөхийг гуйгаарай — энэ бол бүх өдрийн турш таны хийж чадах хамгийн сайн зүйл юм.

Бурханы хайр таныг өөрчилнө. Та Бурхан танд хайртай гэдгийг ухаарч эхлэх үед Түү-

ний хайрыг мэдэрч таны хүсэл өөрчлөгднө. Таныг хайрласан Есүстэй адил болохыг хүсэх болно. Өөртөө цэвэр сайн мөс чанар, зан байдлыг хөгжүүлж улам илүү Бурхантай адил зан чанартай байхыг тэмүүлэх нь бидний гол зорилгын нэг юм. Паул бүхнээс илүү Христийн дахин амилалтын хүч, зовлонгуудыг мэдэхийг хүссэн гэж хэлсэн (Филиппой 3:10 үз).

Би таныг өөрийн Бурхантай харилцах харилцаандаа нухацтай хандахыг уриалж байна. Та хүссэнээрээ Бурхантай дотно байж чадна. Бүх зүйл та хэрхэн зориулалт гаргахаас шалтгаална. Библид бид Түүний бие төлөөлөгч (элчин сайд) бөгөөд Тэр энэ дэлхий рүү биднээр дамжуулан ханддаг гэж хэлдэг (2 Коринт 5:20 үз).

Энхүү эшлэл нь үргэлж миний зүрхийг хөндөж намайг Ариун Сүнсний удирдлагыг дагахын чухалыг шинээр харахыг албаддаг, Тэр бидний дээр хөдөлмөрлөж Бурханы бодол санааны дагуу биднийг өөрчилдөг. Бурханы хайр Ариун Сүнсээр бидний зүрхэнд цутгагдсан (Ром 5:5-ыг үз). Үүнд итгээрэй, Бурханы хайрыг бахдаж хайр таныг болон таны амьдралыг өөрчлөхийг зөвшөөрөөрэй.

Итгэлийн залбирал

Бурхан танд хайртай бөгөөд хувьчилсан харилцаа тогтоохыг хүсэж байна. Хэрэв та Есүс Христийг таны аврагч гэдгийг өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй бол танд боломж байна. Түүнд зүрх сэтгэлээ нээгээд энэ залбирлыг хэлээрэй:

«Ариун Эцэг Бурхан минь, би Таны эсрэг гэмтэй гэдгээ мэднэ намайг уучлаач, намайг цэвэрлээч. Би Таны Хүү Есүс Христэд итгэхээ амлаж байна, итгэж байна. Тэр загалмайд цовдлогдохдоо миний гэмийг Өөртөө үүрсэн. Тэр миний төлөө нас барсанд би итгэж байна. Тэр үхлээс дахин амилсанд би итгэж байна. Би одоо өөрийнхөө амьдралыг Танд өргөж байна. Намайг уучилж, мөнхийн амьдрал өгсөнд баярлалаа. Эцэг Бурхан минь, Тантай хамт амьдрахад надад туслаач Есүсийн нэрээр амен».

Хэрэв та зүрх сэтгэлээсээ гуйсан бол Тэр таныг хүлээн авч сүнсний боолчлолоос таныг

чөлөөлж, цэвэрлэх болно. Библи уншиж Түүнд цаг гаргавал асуултынхаа хариултыг авах ба шинэ амьдралдаа Түүнтэй хамт аялаарай.

Иохан 3:16	1 Коринт 15:3–4
Ефес 1:4	Ефес 2:8–9
1 Иохан 1:9	1 Иохан 4:14–15
1 Иохан 5:1	1 Иохан 5:12–13

Түүнээс Библи болон зөвт сүмийг гуйн асууж Христтэй хамт нөхөрлөн өсөж урамыг аваарай. Бурхан үргэлж тантай хамт, Тэр таны амьдралыг удирдах бөгөөд Тэр таны амьдралыг элбэг хангалуун байлгах болно.

Зохиогчийн тухай

Жойс Майер бол Библийн сургаалыг амьдралд ойр дөтөөр заадаг, дэлхий даяар танигдсан багш нарын нэг билээ. «Баяр хөөрөөр дүүрэн амьдрал» (Enjoying Everyday Life) хэмээх өдөр тутмын нэвтрүүлэг нь дэлхий даяар олон зуун телевизийн сүлжээ, радио станцуудаар цацагдаж байна. Жойс хүмүүсийг урамшуулан зоригжуулсан нийтдээ 100 гаруй ном бичсэн байдаг. Түүний борлуулалтаараа тэргүүлсэн бүтээлүүд нь монгол хэлээр: «Мэдрэмжээ залж амьдрах ухаан», «Итгэл найдвараар ирээдүйгээ хар!», «Оюун ухаан тулалдааны талбар» гэх мэт байгаа.

Жойс жилийн туршид зохион байгуулдаг хурал цуглаануудаараа мянга мянган хүнд хүрч номлон дэлхий даяар идэвхтэй аялж үйлчилдэг.

ЖОЙС МАЙЕРИЙН ҮЙЛЧЛЭЛ МОНГОЛД

Жойс Майерийн монгол хэлээр
орчуулагдсан номууд:

«Амар тайван»

«Амьдралын шинэ зам»

«Итгэл найдвараар ирээдүйгээ хар!»

«Мэдрэмжээ залж амьдрах ухаан»

«Оюун ухаан тулалдааны талбар»

«Хайртай гэдгийг минь тэдэнд хэлээрэй»

«Жойс Майерийн үйлчлэл»-ийн материалудыг
монгол хэлээр орж үзэх ба татаж авах боломжтой:

joycemeyer.mn

[facebook.com/JoyceMeyerMinistriesMongolian](https://www.facebook.com/JoyceMeyerMinistriesMongolian)

YouTube дээр суваг:

[youtube.com/c/JoyceMeyerMinistriesMongolia](https://www.youtube.com/c/JoyceMeyerMinistriesMongolia)

Жойс Майерийн номлолөөр хэл дээр үзэхээр
бол **tv.joycemeyer.org** вэбсайт руу зочлоорой.

Дараах хаяг, утасны дугаараар **холбогдоно уу:**

16092 ш/х 504, Улаанбаатар-23, Монгол улс.

E-mail: **contactus@joycemeyer.mn**

Утас: +976 99700060

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө, 25-р эмийн
сангийн буудал, Кёкүшю цамхагийн 404 тоот

»» Бурхан танд үнэхээр их хайртай «« ГЭДГИЙГ ТА МЭДЭХ ҮҮ?

«Бурхан танд хайртай!» Энэ таны хамгийн олон удаа сонссон үг байх. Мөн хүмүүс «Бурхан дэлхийг үнэхээр их хайрласан учраас» эсвэл «Бурхан бол хайр» гэж Библиээс иш татдаг. Бурхан таныг ямар ч болзолгүйгээр үргэлж хайрладаг гэсэн эдгээр үгсийг та үнэн утгаар нь ойлгож байна уу? Тэр таныг бүтээсэн бөгөөд таны амьдралын бүх зүйлийг тань төлөвлөсөн, Бурханы үнэн таны өдөр тутмын амьдралд тань нөлөөлж байна уу?

Энэхүү номоор та:

- *Илүү гүн, Бурханы хайрын талаар Библи дээр юу гэж хэлснийг.*
- *Мэдэх, Бурханы хайрыг яаж авах ба бусдад хэрхэн бэлэглэх.*
- *Харах, энэ үнэн таны амьдралыг яаж өөрлөхийг.*
- *Ойлгох, яаж өдөр бүр Бурханы хайраар амьдархад суралцах болно.*

Энэ илгээмж нь: Бурхантай хувийн харилцаа тогтоож, Бурханы өгсөн зорилго, боломжийг амьдралдаа хэрэгжүүлэх талаар сурахыг хүссэн Христэд итгэгч хүн бүрт зориулагдсан. Та шинэ итгэгч эсвэл олон жил итгэсэн итгэгч аль нь ч байсан таныг Бурхан руу ойртуулж, та төсөөлснөөсөө ч илүүгээр Түүний хайрыг мэдэж авах болно.